



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 01 сарын 12 өдөр
хот

Төрийн ордон. Улаанбаатар

АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 6 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“6 дугаар зүйл. Сонгуулийн ерөнхий хорооны бүрэн эрх

Сонгуулийн ерөнхий хороо ард нийтийн санал асуулгыг зохион байгуулж явуулах, түүний бэлтгэл ажлын талаар Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.”

2 дугаар зүйл. Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн

“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 15 дугаар зүйлд” гэснийг “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Сонгуулийн төв байгууллагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ